

ДОТООД ХЯНАЛТЫН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Компанийн дотоод хяналтын тогтолцоог бий болгож, түүнд хамаарах нэгжүүдийг байгуулах, тэдгээрийн үйл ажиллагааны чиг үүрэгтэй холбогдох харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилт оршино.
- 1.2. Компанийн дотоод хяналтын тогтолцоонд хамаарах нэгжүүд нь хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол Компанийн засаглалын кодекст заасан шаардлага, зарчмыг хэрэгжүүлж, түүнд заасан журмыг мөрдөнө.
- 1.3. Компанийн дотоодын хяналтын тогтолцоонд хамаарах нэгжүүд нь чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хараат бус байх зарчмыг хэрэгжүүлнэ.

Хоёр. Дотоод хяналтын тогтолцоо, түүний нэгж,
тэдгээрийн бүрэлдэхүүн, ажиллах журам.

- 2.1. Компанийн дотоод хяналтын тогтолцоо нь Аудитын хороо, Дотоод хяналтын алба гэсэн нэгжүүдтэй байна.
- 2.2. Аудитын хороог төлөөлөн удирдах зөвлөлөөс байгуулж, түүний гишүүдийг сонгож, томилно.
- 2.3. Аудитын хороо нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээс бүрдсэн 3 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд түүний удирдлагын дор ажиллана. Аудитын хорооны гишүүдийн гуравны хоёр, мөн хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн байна.
- 2.4. Гүйцэтгэх захирал дотоод хяналтын албыг байгуулж, түүний бүрэлдэхүүний тоо, гишүүдийг аудитын хороотой зөвшилцөж томилно. Дотоод хяналтын алба нь компанийн эрх бүхий албан тушаалтнаас хараат бус бүрэлдэхүүнтэй байх бөгөөд компанийн Гүйцэтгэх захирлын удирдлага дор ажиллана.

Гурав. Дотоод хяналтын нэгжүүдийн чиг үүрэг.

Аудитын хороо

- 3.1. Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих;
- 3.2. Дотоод хяналтын албаны удирдлага, ажилтныг томилох, цалин, урамшууллыг тогтоох санал боловсруулах;
- 3.3. Аудитын байгууллагыг сонгох, түүний ажлын хөлсний хэмжээг тогтоох санал боловсруулах;
- 3.4. Их хэмжээний ба сонирхолын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих, дүгнэлт гаргах;
- 3.5. Компанийн дүрэмд заасан болон төлөөлөн удирдах зөвлөлөөс шаардлагатай гэж үзсэн бусад асуудал:

- 3.6. Аудитын хороо нь улиралд нэгээс доошгүй удаа хуралдаж компанийн үйл ажиллагааны явцад хийсэн хяналт шалгалтын дүнг хэлэлцэж байна.

Дотоод хяналтын алба

- 3.7. Дотоод хяналтын алба нь компанийн өдөр тутмын үйл ажиллагааны хяналтыг хэрэгжүүлж, гүйцэтгэл нь хууль тогтоомж, стандарт, нөхцөл шаардлагын дагуу хийгдсэн эсэх, холбогдох эрх бүхий албан тушаалтан үүргээ зохих ёсоор гүйцэтгэж байгаа эсэх, төсвийн зарцуулалт, санхүү, нягтлан бодох бүртгэлийн өдөр тутмын ажиллагаанд алдаа дутагдал гарч байгаа эсэхийг хянаж, гүйцэтгэх захиралд зөвлөмж өгч ажиллах.
- 3.8. Дотоод хяналтын алба нь хяналт шалгалтын дүнгээ тухай бүр аудитын хороонд хүргүүлж, шийдвэрийн биелэлтээ гүйцэтгэх удирдлагад тайлагнах.

Дөрөв.

- 4.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хороо, гүйцэтгэх удирдлагын дор ажиллах дотоод хяналтын алба нь орон тооны бус байна.
- 4.2. Энэхүү журамд тусгагдаагүй асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрлэнэ.

Төгсөв